

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

САЙНШАНД СУМЫН 2 ДУГААР БАГ “АЛТАН ГОВИЙН” ГУДАМЖ НИЙТИЙН ОРОН СУУЦ 102 ДУГААР БАЙРНЫ ПОДВАЛЫН ХАЛААЛТ, ЦЭВЭР УСНЫ ШУГАМЫН ЗАСВАРЫН АЖИЛ

А. Ажил гүйцэтгэх хугацааны график хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоог тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В. Үнийн саналд зураг төсвийн үнийг **1 256 500 /Нэг сая хоёр зуун тавин зургаан мянга таван зуу/** төгрөгөөр, захиалагчийн хяналтын зардлыг талбайн угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгийн 2%-иар, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тооцож тусгаж ирүүлнэ.

Г. Төсөв зохиохдоо Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 30 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД “IY” 81-95-12-г мөрдлөг болгоно.

Д. Авто тээврийн зардлыг ЗТХС-ын 2022.08.22-ны өдрийн А/233 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.

Е. ЗТХС-ын 2017 оны 212 дугаар тушаалаар машин механизмын зардлыг тооцож ирүүлнэ.

Ё. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

Ж. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.

З. Гэрэлтүүлэг суурилуултын ажлын явцад “Сайншанд сумын цахилгаан түгээх сүлжээ”-ээрхяналт тавиулж холбогдох актыг бүрдүүлэх.

И. Газар шорооны ажлын хийж гүйцэтгэхийн өмнө геодези хэмжилтийн эрхтэй байгууллагаар шугам трассын дагуу улаан шугам тавиулж илд далд ажлын актыг баталгаажуулсаны дараа ажлын эхлүүлэх шаардлагатай. Улаан шугам тавиулах үед захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллийг байцуулна.

1. Халаалтын ажил

Дулаан хангамжийн шугамын засварын ажилыг хийж гүйцэтгэхдээ БНБД 23-01-09/Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт/, БНБД 31-03-03 /Олон нийтийн иргэний барилга/, БНБД 23-02-09 /Барилгын дулаан хангамж/ норм дүрмүүдийг мөрдөж ажиллах. Тус ажлыг гүйцэтгэхдээ хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахиун заавар заварчилгааг чанд сахин мөрдөн ажиллах. Дулааны хоолойг угсрахын өмнө сайтар цэвэрлэж, угсарж дууссаны дараа БНБД 3.05.01-08-ын 0.8МПа-с ихгүй даралтаар шахаж шалган илэрсэн зөрчлийг арилгаад акт үйлдэж, зэврэлтээс хамгаалах лакаар будаж, дулаалгын зориулалтын ороох материалаар ороож хамгаална. Яндан хоолойн гагнуурын ажлыг БНБД 3.05.01-88-ын 5.3-аас 5.13-р зүйлүүдийг зүйлүүдийг мөрдлөг болгно.

2. Дээврийн ажил

Ус хангамжийн ажлыг хийж гүйцэтгэхдээ БНБД 31-03-03/Олон нийтийн иргэний барилга/, БНБД 40-05-16/Барилгын доторх ус хангамж, ариутгах татуурга/ мөрдлөг болгон ажиллана. Цэвэр усны хоолойг угсарж дууссаны дараа БНБД 3.05.01-88-ын 0.6МПа-с ихгүй даралтаар шахаж шалган илэрсэн зөрчлийг арилгаад акт үйлдэж, дулаалан зориулалтын ороох материалаар ороож хамгаална. Усны найрлага нь MN900-2005 ундны усны сатандарт, шаардлагыг хангасан байх шаардлагатай.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Талбайн угсралтын ажлыг батлагдсан төсөв, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
4. Барилгын талбайд хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
5. Талбайн угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
6. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.
7. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
8. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч тухайн ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
9. Ажил гүйцэтгэж дууссаны дараа шугамын трассын дагуу геодези хэмжилтийн байгууллагаар гүйцэтгэлийн зураг гаргуулж ГХБХБГ-ын кадастрын мэдээллийн санд бүртгүүлнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ЧУЛУУНЦЭЦЭГ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:

САЙНШАНД СУМЫН
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

Б.Энхманлай

Б.ЭНХМАНЛАЙ